

**БАТЛАВ:**

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,  
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА

...../Ц.УРАНЧИМЭГ/

**ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ**

**ХҮЛЭЭСЭН:**

“М-БИ-СИ АЗИА ПАСИФИК” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

...../Ц.ЭРДЭНЭБИЛЭГ/



**MBC ASIA PACIFIC**

**2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

**РД: 5027292**

**ХЯНАСАН:**

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ

ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

..... Ж.БАТЗОЛБОО

“М-БИ-СИ АЗИА ПАСИФИК” ХХК-ИЙН

ҮЙЛДВЭРИЙН ДАРГА

..... Б.БОЛОРМАА

**БОЛОВСРУУЛСАН:**

“М-БИ-СИ АЗИА ПАСИФИК” ХХК-ИЙН

ХАБЭА ХАРИУЦСАН ИНЖЕНЕР

..... Г.ГАНБАТ

**2022**

## Агуулга

### **М-Би-Си Азия Пасифик ХХК-ийн 2022 оны БОМТ-ий хэрэгжилт**

1. Товч танилцуулга
2. Байгаль орчны менежментийн тогтолцооны танилцуулга
3. Байгаль орчны хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд
  - 3.1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
  - 3.2. Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө
  - 3.3. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө
  - 3.4. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
  - 3.5. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
  - 3.6. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хөтөлбөр
  - 3.7. БОМТ-ний зардлын товчоо
4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт
5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дүгнэлт
6. Хавсралт

## 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Зорилго

“М Би Си Азиа Пасифик” буюу хүмүүсийн сайн мэддэгээр Тайгер шар айрагны үйлдвэр нь анх 2005 онд Хайнекен Интернейшнл болон М-Си-Эс Групп -ийн хөрөнгө оруулалтаар дэлхийн брэндийг Монголдоо үйлдвэрлэх зорилгоор байгуулагдсан.

### 1.2. Компанийн мэдээлэл

“М Би Си Азиа Пасифик” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011587056

Регистрийн дугаар: 5027292

### 1.3. Үйлдвэрийн хаяг


Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 10-р хороо, Амгалан/13260/ Гачууртын зам-102/1

Утас: 464304, 464306

Факс: 976-11-464314

### 1.4. Үйлдвэрийн байршил

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 10-р хороо, Амгалан/13260/ Гачууртын зам-102/1-д 50000 м2 талбайд үйл ажиллагаа явуулна.



Зураг 1. Компанийн байршил

*Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөл бүхий талбайн өнцгүүдийн газар зүйн солбицлууд*

№	Ү	х
1	5309857,12	651103,39
2	5310023,22	651177,48
3	5309931,70	651383,73
4	5309921,38	651387,92
5	5309923,90	651434,08
6	5309903,56	651426,14
7	5309747,97	651362,51
8	5309760,61	651331,41
9	5309775,78	651295,98
10	5309785,87	651271,87
11	5309795,70	651248,64
12	5309810,86	651212,82
13	5309817,12	651198,30

**1.5. Үйлдвэрийн хүчин чадал**

2010 онд Герман улсын Krones-ийн төхөөрөмжөөр тоноглогдсон цагт 15000ш лаазтай бүтээгдэхүүн савлах хүчин чадалтай лаазны шугам, мөн тус бүр нь 100тн багтаамжтай 11 танк бүхий шинэ Исгэлтийн цехийг ашиглалтанд оруулснаар үйлдвэрийн хүчин чадал 2 дахин буюу 30 сая литр болон нэмэгдсэн. Энэ нь бүтээгдэхүүний тоо, нэр төрлийг нэмэх боломжийг бүрдүүлж өгсөн.


2015 оноос Сэнгүр брэндийхээ төрлийг нэмж улаан буудайн шар айраг Сэнгүр вайт (Sengur white)-ыг худалдаанд гаргаж, 2016 онд нимбэг жимсний амттай Сэнгүр радлер (Sengur radler lemon), 2017 онд алим ба цангис жимсний амттай Сэнгүр радлер (Sengur radler apple, cranberry) шар айргийг тус тус зах зээлд нийлүүлэн, спиртийн агууламж багатай шар айраг хэрэглэгчид тэр дундаа эмэгтэй хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг ханган ажиллаж байна. Энэ онд буюу 2019 ондоо хамгийн отгон брэнд болох манго ба тоор жимсний амттай Сэнгүр радлер (Sengur radler mango, peach) шар айргийг үйлдвэрлэж эхлээд байна.

Монгол улсын засгийн газрын 2018 оны "түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62-р тогтоол болон бусад тушаал, захирамжын хүрээнд 2022.05.15 өдрөөс эхлэн улаанбаатар хотод түүхий нүүрс болон хагас боловсруулсан нүүрс түлэхийг хориглосон болно. Нийслэлийн АБТГ, НЗЗ аас нүүрс түлэхгүй байх асуудалыг дахин сануулж газ, цахилгаан болон төвлөрсөн дулаанд холбогдох зэрэг дэвшилтэт технологи ашиглан халаалт дулаанаа шийдвэрлэх чиглэл өгсөн.

Иймд дээрх нүүрсээр ажиллаж байгаа зуухнуудыг шингэрүүлсэн хийн түлш (LPG) болон дизель түлшээр ажилладаг зуухаар өөрчлөх шаардлага үүссэн. 2022 онд хийн зуухны шинэ төсөлөө амжилттай хэрэгжүүлээ.

### 1.6. Үйлдвэрийн барилга байгууламжууд

Үйлдвэрийн хашаанд үйлдвэрийн байр, бэлэн бүтээгдэхүүний агуулах, түүхий эдийн агуулах, химийн бодисын агуулах, уурын зуух, оффис, харуулын байр болон ажилчдын байр гэсэн үндсэн барилга байгууламжууд болон удирдлага, захиргаа санхүү, хүний нөөцийн алба байрлах оффис, цайны газар, тээврийн хэрэгслийн граж, хаягдлын цэг гэх мэт бусад объектууд байна.



Зураг 2. Үйлдвэрийн барилга байгууламжийн план зураг




Зураг 3. Үйлдвэрийн байр




Зураг 4. Хийн зуух



Зураг 5. Цайны газар



Зураг 6. ОО-ын өрөө



Зураг 7. Граж

### 1.7. Техник, тоног төхөөрөмж

Тайгер шар айргийн үйлдвэрийн гол дамжлагууд нь Герман улсын Кронэс, Хупман фермийнх бөгөөд бүрэн автоматчилагдсан шугамтай, түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, технологийн дамжлага, эцсийн бүтээгдэхүүнийг олон улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа чанарын баталгаажуулалтын тусгай программ болох “QUALASS” чанарын хяналтын системийн дагуу гүйцэтгэдэг. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа олон улсын ISO 22000:2005, ISO 9001:2008 цуврал стандартуудыг нэвтрүүлснээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүний иж бүрэн хяналтын тогтолцоог шинээр мөрдөж, дотоодын хяналтыг тогтмол тавьж ажиллаж байна.



Зураг 8. Үйлдвэрийн тоног төхөөрөмж угсралтын ерөнхий байдал



Зураг 9. Үйлдвэрийн дотоод орчны нөхцөл байдал

**1.8. Хяналт, шинжилгээний лаборатори**

Үйлдвэрийн лаборатори нь 2007 онд анхлан байгуулагдсан бөгөөд лаборатори нь 3 үндсэн хэсэгтэй бөгөөд 1 дагуул лабораторитой. Тус лаборатори нь үйлдвэрт орох бүхий л түүхий эдүүдэд физик, хими болон микробиологийн шинжилгээнүүдийг хийж хүнсний аюулгүй байдалд байнга хяналт тавин ажилладаг. Лаборатори нь магадлан итгэмжлэгдсэн ба 2022 онд дахин итгэмжлэлээ авсан. Мэргэжлийн 4 чанарын шинжээчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.



Зураг 10. Хяналт шинжилгээний лаборатори



### 1.9. Химийн бодисын агуулах

Химийн хортой болон аюултай бодис, нэгдлүүдийг хэрэглэх зориулалтаас хамааран лабораторийн болон агуулахын нөхцөлд хадгалдаг.



Зураг 11. Химийн бодисын агуулахын дотоод нөхцөл

## 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ТАНИЛЦУУЛГА

М-Би-Си Азия Пасифик ХХК компанийн бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь ‘Тогтвортой хөгжил’-ийн үндсэн суурь зарчим болох НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧИН тэнцвэртэй хөгжлийг ханган нийгэм, эдийн засаг, хүн баялагт үнэ цэн бүтээхэд чиглэн ажилладаг билээ. Байгаль орчин тогтвортой хөгжлийн стратеги нь манай компанийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг ба үйлдвэрлэлийн үйл ажиллагааны туршид байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, аюултай материал, ус, эрчим хүч болон бусад байгалийн нөөцийн хэрэглээг хэмнэх, үүсэх хог хаягдлын хэмжээг багасгах, хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх зэрэг зарчимуудыг баримтлан ажилласаар байна. Иймд 2022 оны тогтвортой хөгжлийн стратегийн хүрээнд “Илүү сайхан дэлхийг цогцлооё” уриан доор үйлдвэрлэл үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны менежментийг хэрэгжүүлэн ажиллалаа. Байгаль орчин тогтвортой хөгжлийн хүрээнд бид 2022 онд байгаль орчны менежментийн тогтолцоог сайжруулах,

хэрэгжүүлэлтийг нэмэгдүүлэх, хог хаягдлын менежментийг сайжруулах, байгалийн нөөцийн хэмнэлтийг бий болгох зэрэг үндсэн 3 зорилтын хүрээнд ажилласан билээ.

1. Байгаль орчны менежментийн тогтолцоог сайжруулах, тогтвортой хөгжүүлэх ажлын хүрээнд нийт үйлдвэр нэгж хэсгүүдэд байгаль орчны дэд багуудыг шинэчлэн байгуулж ажилчид гишүүдийн оролцоог нэмэгдүүлэн БОМТ –ны хэрэгжилтийг хангуулахад хамтран ажилладаг боллоо. Үүний зэрэгцээ эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөрийн хүрээнд эрчим хүчний хэрэглээгээ бууруулан ажиллаж байна.

2. Хог хаягдлын менежментийн хүрээнд хог хаягдлын 3R стратегийг үйлдвэр нэгж хэсгүүдэд хэрэгжүүлэн хог хаягдлын цэгүүдийг 5S зарчмын дагуу сайжруулан хог хаягдлын ангилан хаялтыг нэмэгдүүлж байна. Түүнчлэн үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлын хэмжээг бууруулах, газарт шууд хаягдах хаягдлыг багасгах, дахивар хог хаягдлаа эргүүлэн ашиглах, дахин боловсруулахад чиглэн ажиллаж нийт хог хаягдлын дахин боловсруулах хэмжээгээ энэ үеийн өмнөх онтой харьцуулахад 7% -иар нэмэгдүүлж дахин боловсруулах компаниудын түншлэлээ нэмэгдүүллээ. Тухайлбал аюултай болон химийн хорт бодисын сав баглаа боодлыг дахин боловсруулах үйлдвэр Түмэн Эгшиг ХХК болон хаягдал шилийг дахин боловсруулан дулаан тусгаарлагч материалын үйлдвэрлэх компани ТИС ХХК зэрэг компаниудтай хамтран ажиллаж дахивар хаягдлуудаа тус тус нийлүүлсээр байна.

3. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны 24 дүгээр тогтоолын 5.1.1. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ гэхийн дагуу манай компани нь хийн зуухны төсөлөө амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

4. Байгалийн нөөцийн хэмнэлтийн зорилгын хүрээнд дулаан цахилгаан эрчим хүч усны хэрэглээгээ бууруулан ажиллаж байна.

### 3. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АЖЛУУД

3.1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил	Гарах үр дүн	Хариуца х эзэн	Холбогдох хууль, дүрэм журам, аргачлал, стандарт	Зардал мян.төг
<b>Хөрс</b>					
1	Нийт эзэмшил талбайн 10%-иас доошгүй хэмжээний талбайг зүлэгжүүлэх	Нийт талбайн мод бутлаг ургамалын нөхөн сэргээлтийн ажил хийх	Аж ахуйн ажилтан	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4, Нийслэлийн засаг даргын	

				2013 оны А/623 дугаар захирамж	
<b>Агаар орчин</b>					
2	Орчны агаарын шинжилгээг хийгүүлэх	“Ногоон титэм” ХХК-р орчны агаарын шинжилгээг хийлгүүлсэн	ХАБЭА Инженер	Агаарын тухай хуулийн 9.1.4.аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналтыг явуулах;	900.0
3	Химийн бодисын үлдэгдэл бүхий сав, баглаа, боодлийг ил задгай хаяхгүй байх, агуулах савны битүүмжид байнга хяналт тавьж ажиллах	Химийн бодисын агуулахад хадгалах химийн хаягдалын бүртгэл хөтөлсөн. Түмэн эгшиг ХХК-д хаягдалаа тушаасан.	ХАБЭА Инженер	Химийн бодисын ашиглалт зарцуулалтын тайланг гаргаж БЗД-н мэргэжлийн хяналтын хэлтэст хүргүүлж байна.	
4	Хий байдалтай химийн бодисуудын (нүүрсхүчлийн хий, аргон, фреонууд г.м) хадгалалт, ашиглалтын үед алдагдал гарч тэсэрч дэлбэрэхээс урьдчилан сэргийлэх	Хийг агуулж буй савны бүрэн бүтэн байдлыг хянаж бүртгэл хөтөлсөн.	Ашиглалтын супервай зор	Даралтат савтай ажилладаг ажилчдыг сургалтанд хамруулсан	2800.0
<b>Ажилчдын эрүүл мэнд</b>					
5	Ажиллагсдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах, болзошгүй аюулын үед эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан. Шаардлагатай үед хэрэглэх заавар бүхий иж бүрэн эмийн сангийн нөхөлтийг улирал бүрт бүрдүүлэн анхны тусламжийн хэрэгслээр ханган ажиллаж байна.	ХАБЭА Инженер		2200.0
6	Нийт ажилчдыг хөдөлмөр	Ажиллагсдыг хөдөлмөр хамгаалалын хувцас			1000.0

	хамгааллын хэрэгслээр хангах, гал унтраах багаж хэрэгслийг байршуулах	хэрэгслээр хангаж, Компанийн хэмжээнд 2022 онд 10 ширхэг гал унтраагуурыг шинээр сольсон. Мөн дууссан ашигласан гал унтраагууруудыг дахин цэнэглэж байна.			
Нийт зардал					

### 3.2. Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах үүднээс ахуйн болон үйлдвэрийн гаралтай хатуу, шингэн, хог хаягдалыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө багатайгаар хэрхэн цуглуулж, ангилан, дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлсэн.

Хүснэгт 1 Гаргах хог хаягдалын ангилал

Бүлгийн код	Хог хаягдалын төрөл		Жилд гарах хэмжээ	Зайлуулах арга хэмжээ	
Т-0301	Устгах дахин ашиглах боломжгүй хог хаягдал	Ангилан ялгах боломжгүй ахуйн хог хаягдал	83 тн	“Эко Орчин” ХХК	
		Эргэлтийн шилний цаасан хаяг	0.2 тн		
Б-0301	Дахин ашиглагдах хог хаягдал	Чаналагаас гарсан шаар, хаягдал хөрөнгө, шигшигдсэн үр тариа	2214 тн	Малчдад болон Баялаг Фийд ХХК	
О-0106		Шуудай	11 тн	2 догч түүхий эд авах цэгт өгнө	
Т-0127		Хуванцар	600 кг	Хувь хүмүүст нийлүүлдэг	
О-0103		Модон поддон	52 тн	Хувь хүмүүст нийлүүлдэг	
		Хагарсан шил	200 тн	“Эко Орчин” ХХК	
О-0104		Лааз, төмөр	3 тн	2 догч түүхий эд авах цэгт өгнө	
Т-0129		Аюултай хаягдал	Зуухны доод үнс, яндангийн хөө	300 тн	Улаанбаатар шинэчлэл ХХК гэрээний дагуу
О-0109			Химийн бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол, шингээгч, бохир алчуур, фильтрийн материал, ажилласан тос	2.0 тн	“Түмэн эгшиг” ХХК

Хүснэгт 2 Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

Эх үүсвэрээс гарах хог хаягдалын төрөл	Жилд гарсан хэмжээ	Дахин боловсруулахад, ашиглах	Устгах	Хадгалах	Нэг удаа зайлуулах зардал	Тээвэрлэгчид нийлүүлэх, мян.төг
Дахин болон дахин ашиглах боломжгүй хог хаягдал	2865 тн	2482 тн	382 тн	-	200.0 мян.төг (1 рейс)	16400.0
Шингэн	72600м <sup>3</sup>	х	72600м <sup>3</sup>	х	х	117000.0
Аюултай, хортой	Химийн	2.0тн	2.0тн	х	х	8000.0
Нийт						131000.0

3.3 Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 3 Компаний удирдлагын зүгээс хийж гүйцэтгэсэн ажлын үнэлгээ

№	Зохион байгуулах ажил	Авсан арга хэмжээ	Хийгдсэн хугацаа	Гарсан зардал	Үнэлгээ	Хувь
1	Хог хаягдлыг бууруулах багын ажиллагаа	Байгаль орчинд гаргаж байгаа химийн бодис, физик нөлөөлөл, хог хаягдалын хэмжээг бүртгэж тэдгээрийг багасгах, цэвэрлэх, төвлөрсөн цэгт цуглуулж ажилласан	2022	-	A	100%
2	Хог хаягдалын гэрээг сунгуулах	“Эко Орчин” ХХК “Улаанбаатар шинэчлэл” ХХК “Мултипак” ХХК “Шинэ шил” ХХК	2022.01.01	65сая	A	100%
3	Энергийн зарцуулалтыг бууруулах болон DROP C хөтөлбөр	Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг хянан ( ус ашиглалт, цахилгаан ашиглалт, хог хаягдал, дулаан ашиглалт г.м ) жил бүр зорилт тавин ажиллаж сар бүр KPI-гийн үзүүлэлтэй бууруулан ажилласан			A	100%

4	Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ.	<b>“И ЭЙЧ ЭС ЭМ” ХХК-р</b> байгаль орчны аудитыг хийлгүүлсэн	2022.05.03	22сая	A	100%
5	Аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, ажлын байрны орчинд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох, эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх, газрын дор, хортой, халуун, хүнд нөхцөлийг тодорхойлон хэмжилт, судалгаа хийх, үнэлгээ өгөх, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгоход ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үнэлгээ хийлгэх	2015 онд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэсэн ба 2022онд дахин ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг ХАБЭМ төвөөр хийлгэсэн.				
<b>Нийт дундаж</b>						<b>100%</b>

### 3.4 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 4 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

Хийгдэх ажил	Зарцуулсан зардал мян,төг	Хариуцах эзэн	Үнэлгээ	Хувь
Химийн бодисыг тээвэрлэхдээ сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдал, машин техник, тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтлийг хянадаг байх	-	Гэрээнд аюулгүй ажиллагааны заавар тусгагдсан байдаг.	A	100%
Жолооч, ачигчид тээвэрлэлтийн явцад эрсдэл тохиолдсон үед авах арга хэмжээ, зааварчилгааны талаар мэдлэгтэй байх, асгарч алдагдсан үед хураан авах, саармагжуулах, хоргүйжүүлэх багаж хэрэгсэл, гал унтраах багаж хэрэгсэлийг бэлтгэн, бэлэн байлгах	-	Журмыг тээвэрлэгч нарт танилцуулдаг. Худалдан	A	100%

		авалтын ажилтан хариуцна.		
Химийн бодисуудыг битүүмжлэл сайтай хуурай сэрүүн, агааржуулалт сайтай агуулахад халаалт, гал авалцах эх үүсвэрээс хор аюулын мэдээлэлд заасны дагуу хадгалах	-	Агуулахын менежер	A	100%
Химийн бодисыг хадгалах журам, аюулгүй ажиллагааны талаар ажиллагсад мэдээлэл олгох, сургалт зохион байгуулах	-	Агуулахын менежер	A	100%
Агуулахын гадна болон дотор химийн бодисын хор аюулыг анхааруулсан тэмдэг тэмдэглэгээг байршуулах, агуулахын орчим ил гал гаргах, тамхи татахгүй байх	-	ХАБЭА Инженер	A	100%
Химийн бодис хадгалах агуулахыг стандартын дагуу ашиглах, тогтмол хянах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх, засварлах	-	Агуулахын менежер	A	100%
Ажиллагсдыг химийн бодистой ажиллах хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр бүрэн хангах, хэрэглэж хэвшүүлэх		ХАБЭА Инженер	A	100%
Химийн бодис асгарч алдагдах, ажиллагсад хордох, бэртэх гэмтэх, галын аюулын үед бодисыг хураан авах сав, хүрз, хоргүйжүүлэх саармагжуулах бодис урвалж, яаралтай тусламжийн эмийн сан, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц бололцоог бэлэн байлгах	Нормын дагуу хор саармагжуулах бүтээгдэхүүн олгосон.	ХАБЭА Инженер	A	100%
Химийн бодисын үлдэгдэл, сав баглаа боодлыг ил задгай хаяхгүй байх, зохих журмын дагуу устгах, зайлуулах, хяналт тавих	8000.0	ХАБЭА Инженер	A	100%
Химийн бодисуудын болон аюултай хог хаягдлын агуулахад химийн бодисуудын сав баглаа боодлыг хадгалахдаа эмх цэгцтэй, хаяг шошгожуулсан байх	-	Агуулахын супервайзор	A	100%
Болзошгүй эрсдэл тохиолдсон үед авах арга хэмжээ, эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрсдлийн сан үүсгэх, байнгын бэлэн байдалд байлгах	-	ХАБЭА Инженер	A	100%
Нийт				100%

### 3.5 Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төсөл хэрэгжүүлэгч нь төслөөс хүрээлэн буй орчин, ажлын байрны дотор үзүүлж буй сөрөг нөлөөллийг тодорхойлох зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан хөрс, ус, агаараас жил бүр тогтоосон хугацаанд дээж авч, шинжлүүлэх, гарсан үр дүнг холбогдох байгууллагуудад тайлагнах үүрэгтэй.

Хүснэгт 5. 2022 онд орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хийлгэсэн зардал


Хяналт шинжилгээний чиглэл	Дээжний тоо	Нийт төсөв мян, төг	Нийт гүйцэтгэл мян,төг
Агаар	1	300.0	450.0
Хөрс	1	300.0	450.0
Ус	12	31.0	372.0
Нийт		410.0	872.0

### 3.6 Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хөтөлбөр

Хийн зуухны төсөл

ШААРДЛАГА	Монгол улсын засгийн газрын 2018 оны ”түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62-р тогтоол болон бусад тушаал, захирамжын хүрээнд 2022.05.15 өдрөөс эхлэн улаанбаатар хотод түүхий нүүрс болон хагас боловсруулсан нүүрс түлэхийг хориглосон болно.  Нийслэлийн АБТГ, НЗЗ аас нүүрс түлэхгүй байх асуудалыг дахин сануулж газ, цахилгаан болон төвлөрсөн дулаанд холбогдох зэрэг дэвшилтэт технологи ашиглан халаалт дулаанаа шийдвэрлэх чиглэл өгсөн. Иймд дээрх нүүрсээр ажиллаж байгаа зуухнуудыг шингэрүүлсэн хийн түлш (LPG) болон дизель түлшээр ажилладаг зуухаар өөрчлөх шаардлага үүссэн.
ЗОРИЛГО	Нүүрсээр ажилладаг DZL4-1.25-АII зуухнуудыг шингэрүүлсэн хийн түлш (LPG) болон дизель түлшээр ажилладаг зуухаар сольж өөрчлөх
БАЙРШИЛ	Улаанбаатар хот Баян зүрх дүүрэг 10-р хорооны нутаг дэвсгэр АПУ хк, MBC Азия Пасифик ххк ийн тайгер үйлдвэрийн байр.
ХУГАЦАА	2021.12.01-2022.07.31
ГҮЙЦЭТГЭГЧ	БНХАУ ийн Central International Machinery Co., LTD (туслан гүйцэтгэгч: Thermo Calorie LLC)





Хийн зуухны төсөл нь 2022 оны төлөвлөгөөт усралт ашиглалтын үйл ажиллагаа 100 хувь дууссан ба, холбогдох хяналтын байгууллагын үйл ажиллагаа үргэлжилж байна.

Төсөл нь нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### 3.7 БОМТ-ний зардлын товчоо

Хүснэгт 6 2022 оны БОМТ-ий зардлын товчоо

№	Ажлын чиглэл	2022 оны төсөв мян, төг	2022 оны гүйцэтгэл мян, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	700.0	700.0
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	гүйцэтгэлээр	65000.0
3	Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	6600.0	8000.0
4	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	18000.0	18000.0
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	890.0	1100.0
6	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	6000.0	6000.0
	Нийт		99500.0

## 4. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Бид шингэн хүнсний салбарын тэргүүлэгч компанийн хувьд үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн сүлжээндээ өөрсдийн бэлтгэн нийлүүлэгч, харилцагчдаас байгаль орчны талаар илүү хариуцлагатай бодлого баримтлан хамтдаа харилцан туршлагаа солилцон тогтвортой хөгжихийг уриалан хамтран ажиллаж байна. Бид 2022 онд НҮБ – аас баталсан дэлхийн улс орнууд бүх нийтээр дэмжин хүн бүрт хөгжил цэцэглэлтийг хүртээмжтэй байлгах, ядуурлыг бууруулах, эх дэлхийгээ хамгаалахыг зорьж буй тогтвортой хөгжлийн 17 зорилтыг хэрэгжүүлэх хүчин чармайлтаа эрчим нэмэгдүүлэн ажиллаж байна. Бидний зорилго бол эх дэлхийдээ үзүүлэх аливаа сөрөг нөлөөллүүдийг хязгаарлаж, нийгэм, эдийн засагт оруулах эерэг хувь нэмрийг нэмэгдүүлэх юм. Үүний дотор байгаль орчин тогтвортой хөгжлийн хувьд нөөцийн үр ашигтай менежментэнд тулгуурлан байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлдвэрлэл эрхэлж тогтвортой нийгмийг бий болгоход хувь нэмрээ оруулах байгаль орчны бодлого доор үйл ажиллагаагаа явууллаа. Тайлангын дараах хэсгүүдээс үйл ажиллагааны гүйцэтгэлтэй танилцана уу.



#### 4.1. Удирлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

“М Би Си Азия Пасифик” ХК-ийн байгалийн нөөцийн менежмент, түүний зохистой хэрэглээ, хог хягдлын менежмент, хүрээлэн буй орчинд нөлөөлж болзошгүй эрсдлийн менежмент, орчны хяналт шинжилгээ зэрэг чиглэлүүдэд үйл ажиллагаагаа явуулж Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг ханган ажиллуулах зорилттойгоор ажиллаж байна.

*Ажлын гүйцэтгэл:* Байгаль орчны менежментийн тогтолцооны хэрэгжилтийг сайжруулах ажлын хүрээнд үйлдвэрийн нэгж хэсгүүдэд байгаль орчны дэд багуудыг байгуулж, багийн гишүүдийг шинэчлэн үүрэг хариуцлагыг тодорхойлсон. Үүний үр дүнд компанийн ажилчдын идэвхи оролцоог нэмэгдүүлж, ажилчдын дундах байгаль орчны мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэн, зөв дадал зуршлыг суулгаж ажилтан бүрийн оролцоотойгоор байгууллагын байгаль орчны бодлогыг хамтдаа хэрэгжүүлж байна.

*Ажлын гүйцэтгэл:* Манай компанийн хувьд HEINEKEN -ийн амь насаа хамгаалах амлалтуудыг баримтлан ажилладаг ба 2022 онд бүхий үйлдвэр үйл ажиллагааны хүрээнд бүрэн мөрдөн ажиллаж байна.

*Ажлын гүйцэтгэл:* 2022 оны хувьд хог хаягдлын менежментийг сайжруулах бодлогод илүүтэй төвлөрч нийт ажилчдын хог хаягдлын талаарх ойлголт, ангилан хаялтын тухай мэдлэгийг сайжруулахыг зорин дотоод болон гадаад (Улаанбаатар хотын захирагчын алба, Өнгө Нэм ТББ) үүсвэрээс хэд хэдэн хог хаягдлын менежментийн талаарх сургалтуудыг зохион байгуулж хамаарах ажилчидыг хамруулсан.

*Ажлын гүйцэтгэл:* Хог хаягдлын менежментийн хүрээнд хамтран ажиллагч байгууллагуудтайгаа жил бүр гэрээг 1 жилийн хугацаатайгаар сунган ажилладаг билээ. Байнгын харилцагч түншлэлүүд болох Эко – орчин ХХК – тай энгийн хог хаягдлын менежментийн гэрээ, Түмэн Эгшиг ХХК -тай химийн бодисын сав баглаа боодлын гэрээг сунган баталсан. Мөн түүнчлэн хог хаягдлын дахин боловсруулах компаниудтай хамтын ажиллагаа тэлэн гэрээ хэлэлцээрийг хийсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг хог хаягдлын менежментийн арга хэмжээний биелэлтийн хэсгээс харна уу.

*Ажлын гүйцэтгэл:* Бид 2022 онд Тогтвортой хөгжлийн зургаан зорилтод төвлөрөн үйл ажиллагаагаа уялдуулан хэрэгжүүлсэн билээ. Үүний дотор байгаль орчинд холбогдох “ Хуурай газрын эко системийг хамгаалах ” , “ Уур амьсгалыг өөрчлөлтийн нөлөөг бууруулах ” , “ Хариуцлагатай хэрэглээг дэмжих ” зэрэг зорилтуудад хувь нэмрээ оруулахыг хичээн дараах төслүүдийг хэрэгжүүлэв.

1. “Чи чадна” төсөл



“Чи чадна” – Төслийн медиа зар суртчилгаа – Олон нийттэй харилцах алба

	“Чи чадна төсөл” Social Activity	Budget	Total Reach	Comment
1	“Чи чадна” – Шилээ дахин амьдруулья төсөл дугуйт реклам	30,000,000	1,020,000	10-15 секундийн Богино б шторк болгож, мэдээний оргил цаг, социал сүвгүүдээр нийтлэв.
2	Төслийн контент, рекламг ТВ, Сайт, Сэтгүүл, Социал сүвгүүдээр цацах.	24,286,400	30,000	Нийт 11 богино шторк, 3 сурвалжлага, 2 лайв нийтлэв.
3	Шил буцаан авах цэгүүдийн байршил заасан гэрэлт самбаруудыг байршуулах, социалаар цацах.	3,000,000	173,054	Шилний буцаан авалтын 9 дүүргийн цэг, постерыг нийт 30 самбарт байршуулав.
4	Хөдөө орон нутаг, алслагдсан сум дүүрэгт шилээ буцаан авч буй тухай контент.	3,000,000	93,923	30-40 секундийн 3 богино шторк болгон NTV-ийн мэдээний оргил цагуудаар нийтлэв. /NTV-тэй хамтран ажиллах гэрээний хүрээнд/
5	Шилний буцаан авалтын тухай лайв, нийтлэл, сурвалжлага, ярилцлага	-	20,000-30,000	NTV, Zarig, EDU, TV9, ikon, gogo.mn, time.mn хамтран бүрэн хэмжээний сурвалжлага, нийтлэл, ярилцлага, лайв нийтлэв.
6	Alaga&Nyamka хамтран Гангстерууд Баярлалаа влог 5 Alaga&Nyamka хамтран шилээ буцаан тушаахыг уриалсан контент	-	793,000	Alaga&Nyamka хамтран Баярлалаа влогт нэгдэж, шилээ буцаан тушаахыг уриалсан бүрэн хэмжээний контент хийв.
		<b>Total budget:*</b> 60,286,400		

Нийт 29 контент

\*Брэнд маркетинг зардал багтаагүй



Чи чадна төслийн тухай мэдээ сурвалжлага, нийтлэл, лайвыг тогтмол NTV, Zarig, EDU, TV9 сүвгүүдээр цацав.

APU COMPANY  
Absolute Pure Ulaanbaatar



Чи чадна төслийн шил буцаан авах байршил заасан контент



“Чи чадна” төсөл - Шилээ дахин амьдруулья дугуйт реклам




Шилээ буцаан тушаах нь байгальд ээлтэй, эдийн засагт хэмнэлттэй талаарх бүрэн хэмжээний контент



Чи чадна төсөл – Шил тушаах цэгүүдийн мэдээллийг төмөр зам дагуух самбарууд дээр байршуулав.

Талбар дээрх гүйцэтгэл



Харилцагчийн хамралт: 120% (961 харилцагч )

OFF Trade – 209  
ON Trade – 276  
Region – 67  
Бусад – 409



## 4.2. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн үйлдвэрлэл үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд нөлөөлж буй болон болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

### Жилийн туршид тогтмол хийн гүйцэтгэсэн ажлууд:

1. Үйлдвэрийн гадна орчныг хаврын улиралд тохижуулан зүлэгжүүлж, тогтмол цэвэрлэгээ арчилгааг хийсэн




2. Техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянан ханган ажиллаж хүрээнд Түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүний тээвэрлэлтэнд ашиглах машинг жил бүрийн тогтмол техникийн үзлэг оношилгоонд оруулан, агаар бохирдуулсаны төлбөрийг төлсөн. 45 машин улсын үзлэг оношлогоонд орсон, агаар бохирдуулсаны төлбөр төлсөн

Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

**Төлөвлөгөөний гүйцэтгэл:** Өөрийн лабораторит сар бүр үйлдвэрийн хаягдал бохир усны шинжилгээг хийн гүйцэтгэж хүрэлэн буй орчинд нийлүүлэх цэвэрлэсэн бохир усны техникийн шаардлага MNS 4943 : 2015 стандартын үзүүлэлтүүдийг тогтмол хянаж байна. Мөн улирал бүр Ус сувгийн удирдах газрын лабораторит бохир усны дээжийг шинжлүүлэн баталгаажуулан тогтмол хяналтандаа байлгаж байна.

Усны нөөцийг хэмнэх, дахин ашигласан усны хэмжээ, хэрэглээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд үйлдвэрийн цех бүрийн усны хэрэглээг нарийвчлан тооцон анализ хийж, тоног төхөөрөмж, шугам хоолойн алдагдлыг олж тодорхойлон инженерийн болон техникийн аргачилалаар шийдвэрлэн сайжруулах, шинэчлэх арга хэмжээүүдийг авч нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны нормыг хамгийн боломжит бага хэмжээнд хүргэж өмнөх онтой харьцуулахад 0,1Нl -р усны хэрэглээгээ буурууллаа.




Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

**Жилийн туршид тогтмол хийн гүйцэтгэсэн ажлууд:**

Тусгай зөвшөөрөл бүхий хог хаягдлын үйлчилгээ үзүүлэх, дахин боловсруулах устгах үйл ажиллагаатай байгууллагуудтай гэрээ хэлэлцээрийн дагуу ажиллаж үүссэн болон цугларсан хатуу ба аюултай хог хаягдлыг тухай бүр ачуулан дахин боловсруулах болон устган зайлуулах арга хэмжээ рүү шилжүүлж байна. Хог хаягдлын төвлөрсөн цэгт ангилан ялгалтын дагуу хуримтлуулж холбогдох компаниуд руу нийлүүлдэг ба тогтмол цэвэрлэгээ үйлчилгээ хийгддэг тул хөрсөн давхаргад нөлөөлөх шууд сөрөг нөлөөгүй. Үйлдвэрийн нийт ногоон байгууламж бүхий талбайг тогтмол тордон арчлан, усладаг. Машин техникийг тогтоосон тээврийн хэрэгслийн зам талбайгаар зоричуулдаг.

Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

**Төлөвлөгөөний гүйцэтгэл:**





Зураг 12. Үйлдвэр орчмын ногоон байгууламж

1. Үйлдвэрийн гадна орчинд жил бүр мод суулгацыг шинэчлэж зүлэгжүүлдэг.
2. “Мод бид 2” төслийг амжилттай хэрэгжүүлсэн. (Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн хэсгээс харна уу.)

Цахилгаан эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2022 онд цахилгаан эрчим хүчний хэрэглээг бууруулах зорилтын хүрээнд эрчим хүчний баг болон эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөрийн хүрээнд цахилгаан, уур, дулааны алдагдлыг тодорхойлон, энергийн алдагдлыг арилгаж хэрэглээний хэмнэлтийг хийж байна. Уур, дулаан, цахилгааны зарцуулалт үйлдвэрийн хэсэг бүрээр тодорхойлон хянаж, их хэрэглээтэй нэгж хэсэг болон тоног төхөөрөмжийн хэрэглээг бууруулах, сайжруулах арга хэмжээнүүдийг авч байна.





### 4.3. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Химийн бодисын хадгалалтад Монгол Улсын хууль, дүрэм журмууд болон компанийн дотоод журам болох химийн бодисын хяналтын тухай журмын дагуу хяналт тавин ажиллаж байна. Компанийн хэмжээнд нийт 92 нэр төрлийн химийн бодисыг төв лаборатори болон үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээнд ашиглаж байна. Үйлдвэрийн технологи болон тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээнд ашиглах бодисуудыг “Soruga” олон улсын компанийн бодисыг хэрэглэдэг ба лабораторийн хэрэгцээний химийн бодисуудыг дотоодын компаниудаас худалдан авдаг. Бодисуудын сав, баглаа боодол бүрэн бүтэн эсэхийг шалган тээвэрлэх бөгөөд бодисууд нь хоруу чанар багатай, тогтвортой шинж чанартай. Хадгалалтын хувьд химийн бодисуудыг “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага. “MNS 6458:2014”- ийн шаардлага хангасан агуулахад хадгалах журмын дагуу ангилан, нэр хаяг, шошго, анхааруулах үг, тэмдэг тэмдэглэгээ, хор аюулын мэдээллийг байршуулан хадгалах тул санамсаргүй осол, эрсдлээс бусад тохиолдолд сөрөг нөлөө бага. Үйлдвэр үйл ажиллагааны хүрээнд ашиглаж буй бүх химийн бодисыг ХАЛМ-тай байлгаж бүртгэлжүүлэн ажиллаж байна. Бодисууд нь 25-200кг болон 20-200л-ийн хэмжээ шуудай, хуванцар савлагаатай.

№	Төлөвлөгдсөн ажил	Биелэлт
<b>Тээвэрлэх</b>		
1	Тээвэрлэлт хийж буй жолооч нарыг сургалтанд хамруулж, химийн бодисын	Химийн бодисын хор аюул, аюулгүй ажиллагааны талаарх сургалтанд хамрагдсан гэрээт компаний



	хор аюул, аюулгүй ажиллагааны талаарх мэдлэг олгох	ажилчид тээвэрлэлтэд ажилладаг ба холбогдох үйлдвэрийн ажилчид химийн бодисын аюулгүй ажиллагааны сургалт болон “М Би Си Азия Пасифик” ХК -ийн дотоодод мөрдөгдөх шинэчлэгдсэн химийн бодисын хяналтын тухай журмын танилцуулах сургалтанд хамрагдсан.
2	Химийн бодисыг тээвэрлэхдээ сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг ханадаг байх, асгарч алдагдсан тохиолдолд хураан авах саармагжуулах, хоргүйжүүлэх материал, гал унтраах багаж хэрэгслээр тээврийн хэрэгслийг тоноглох	Тээвэрлэлтийн гэрээт компаниудад Химийн бодисыг тээвэрлэхдээ сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг ханадаг байх, асгарч алдагдсан тохиолдолд хураан авах саармагжуулах, хоргүйжүүлэх материал, гал унтраах багаж хэрэгслээр тээврийн хэрэгслийг тоноглох шаардлагыг тавин ажилладаг.
<b>Хадгалах</b>		
3	Химийн бодисуудыг битүүмжлэл сайтай хуурай, сэрүүн, агааржуулалт сайтай агуулахад бодисын хор аюулын мэдээлэлд заасны дагуу хадгалах	Химийн бодисын агуулахад бодисын хор аюулын мэдээлэлд заасны дагуу химийн бодисууд хадгалагдаж байна.
4	Химийн бодисын агуулахыг стандартын дагуу тохижуулах, агуулахыг орчим ил гал гаргах, тамхи татахгүй байх	Химийн бодисын агуулахын стандартын дагуу тохижуулалт хийгдсээр байгаа ба агуулахын орчим ил гал гаргах эрсдлээс сэргийлсэн галын дохиолол болон яаралтай үеийн галын аюулгүй байдлын тусламж байрлуулсан. Мөн зөвшөөрөгдсөн тамхи татах цэг агуулахын ойр орчим байрладаггүй.
5	Химийн бодис асгарч, алдагдах, ажиллагсад хордох, бэртэх, гэмтэх, галын аюулын үед бодисыг хураан авах сав, хүрз хоргүйжүүлэх саармагжуулах бодис урвалж, яаралтай тусламжийн эмийн сан, гал унтраах багаж хэрэгсэл бэлэн байлгах	Химийн бодисын агуулахад химийн бодис асгарч, алдагдах, ажиллагсад хордох, бэртэх, гэмтэх, галын аюулын үед бодисыг хураан авах сав, хүрз хоргүйжүүлэх саармагжуулах бодис урвалж, яаралтай тусламжийн эмийн сан, гал унтраах багаж хэрэгсэл бүрэн байршуулагдсан.

6	Болзошгүй эрсдэл тохиолдсон үед эрсдлийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрсдлийн сан үүсгэх, байнгын бэлэн байдалд байлгах	Компаний дотоод онцгой байдалд бэлэн байх, хариу арга хэмжээ авах журмаар зохицуулагдан байнгын бэлэн байдлыг ханган ажилладаг.
<b>Эрсдэлд тохиолдсон үед авах арга хэмжээ</b>		
7	Гал гарсан тохиолдолд гал унтраагуур, гал түймрийн голомтод ажиллагсдыг бүх биеийг хамгаалах хувцас, хэрэглэл, бээлий, хорт утааны багтай ажиллах нөхцлөөр хангах	Галын аюулын сан нь гал унтраагуур, хамгаалах хэрэглэл, бээлий зэргийг бэлтгэн шинэчилж байрлуулсан.
8	Химийн бодис асгарсан тохиолдолд химийн бодис хадгалах, зориулалтын саванд цуглуулах, шингээгч материал ашиглах, асгарсан талбайг сайтар цэвэрлэх, агааржуулах	Химийн бодисын агуулахад гэнэтийн үед химийн бодис асгарсан тохиолдолд химийн бодис цуглуулах, хадгалах зориулалтын сав, шингээгч материал зэргийг шинэчилж сайжруулж байна.
9	Нүд, арьс салст, амьсгал болон залгисан тохиолдолд зааврын дагуу арга хэмжээ авах, эмнэлгийн анхан тусламж үзүүлэх	Химийн бодисын агуулахад яаралтай үед хэрэглэх эмнэлгийн анхан тусламжийн сан болон нүдний зайлуур болон шүршүүрүүдийг байнгын шалгаж шинэчилж байна.
10	Ноцтой ослын үед аюулын бүс тогтоох, энэ талаар мэргэжлийн байгууллага (ОБЕГ, МХЕГ)-д нэн даруй мэдэгдэж орчны хяналт шинжилгээний талаар дүгнэлт гаргуулах, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах	ОБЕГ -ын гэнэтийн аюул ослын сургалтанд ажилчдыг хамруулдаг ба ноцтой аюул ослын үед хамтран ажиллахад бүрэн бэлтгэлтэй байдаг.

#### 4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

“М Би Си Азия Пасифик” ХК нь хог хаягдлын менежментийг үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлын хүрээнд хэрэгжүүлдэг ба хог хаягдлын хэмжээг бууруулах, ландфиллд хаягдах хаягдлыг багасгах, дахивар хог хаягдлаа эргүүлэн ашиглах, дахин боловсруулахад чиглэн ажиллаж байна. Үүний хүрээнд газарт хаягдах хог хаягдлын хэмжээ буурч энэ үеийн өмнөхтэй харьцуулахд дахин ашиглах хэмжээ 7% -иар нэмэгдсэн байна. Бид хог хаягдаа дахивар болон идэвхгүй хаягдал зэргээр дөрвөн төрөлд ангилж, цааш нь дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч болон дахин боловсруулах ком паниуд руу нийлүүлдэг. Тухайлбал аюултай болон химийн хорт бодисын сав баглаа боодол болон хаягдал шилийг дахин боловсруулах үйлдвэрүүд рүү тус тус нийлүүлдэг боллоо. Үйлдвэрлэлээс гарч буй органик түүхий эд болох улаан буудай, арвайн соёолжийн үлдэгдлийг малчид фермерүүдэд, хаягдал хөрөнгө, шаарыг тэжээлийн үйлдвэрт тогтмол нийлүүлж байна.



*Ахуйн буюу энгийн хатуу хог хаягдал*

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломжийг бүрдүүлэн, хогийн савнуудын хаягжилтыг шинэчлэн, үйлдвэр бүрт бүртгэлжүүлэн, төвлөрсөн хогийн



цэгийг сайжруулсан. Мөн оффисын хог хаягдлыг ангилан ялгах боломжийг сайжруулан, хогийн савнуудыг стандартад нийцүүлэн шинэчлэн байрлуулсан. Үйлдвэр болон оффисын орчинд хог хаягдлыг дахивар, цаас, ахуйн болон аюултай хог хаягдал гэсэн 4 бүлэгт хуваан хог хаягдлыг ангилаж байна. Төвлөрсөн хогийн цэгээс энгийн хог хаягдлыг Эко орчин ХХК тээвэрлэн, дахин боловсруулах дахин ашиглах аж ахуйн нэгж хувь хүн байгууллагууд руу нийлүүлдэг. Дахин боловсруулагдахгүй хог хаягдлыг БЗД - ТҮК ХХК морингийн даваан хог хаягдлыг төв цэгт аваачдаг.



*Аюултай болон эмнэлгийн хог хаягдал*

Аюултай болон химийн хорт бодисын сав баглаа боодол, зайг дахин боловсруулах, устгах үйл ажиллагааны үйлдвэр Түмэн Эгшиг ХХК, эмнэлгийн аюултай хог хаягдлыг Элемент Мэдикал ХХК -д тус тус нийлүүлж байна.



Хадгалалтын хувьд хог хаягдлын төвлөрсөн цэгт тусдаа аюулгүй байдлыг нь ханган хадгалдаг. Хаягдал химийн бодисын сав баглаа боодлын нэр хаяг, шошго, анхааруулах үг,

тэмдэг тэмдэглэгээ, хор аюулын мэдээллийг байршуулан хадгалан санамсаргүй осол, эрсдлээс урьдчилан сэргийлэн ажилладаг.

### Шингэн хог хаягдал



Үйлдвэрлэлээс гарах шингэн хаягдлын хувьд органик түүхий эд болох улаан буудай, арвайн соёолж, хөрөнгийн үлдэгдэл, шар айраг шүүлтүүрийн материал кизелгүр гардаг. Улаан буудай, арвайн соёолж, хөрөнгийн үлдэгдэлийг малчид фермерүүдэд, хаягдал хөрөнгө, шаарыг тэжээлийн үйлдвэр “Баялаг фийд” ХХК -д тогтмол нийлүүлж байна. Харин шар айраг шүүлтүүрийн материал кизелгүрийг шахагч прессэр төхөөрөмжийг суурилуулан усгүйжуулж хатуу хог хаягдал болгон шилжүүлж байна. Ийнхүү төв цэвэрлэх байгууламжад нийлүүлэгддэг хаягдал усны бохирдлыг бууруулж байна.



## 5. ДҮГНЭЛТ

“М Би Си Азия Пасифик” ХХК буюу хүмүүсийн сайн мэддэгээр Тайгер шар айрагны үйлдвэр нь байгуулагдсан цагаасаа эхлэн Үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа түүний нөлөө нь байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй ээлтэй байлгах, байгалийн нөөцийг зөв зохистой хэрэглэх, байгаль орчинд үлдээх ул мөрөө бага байлгах зорилгоор Олон улсын Heineken компани болон АПУ групп компанийн байгаль орчны менежментийн тогтолцоо стандартыг хэрэгжүүлэн, бүтээгдэхүүн бүрийг олон улсын стандартад нийцүүлэх зорилтын хүрээнд хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO22000, Чанарын менежментийн тогтолцооны стандарт ISO9001:2015 стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж чанар, бүтээмж, менежментээ ямагт сайжруулан ажиллаж байна. Мөн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор Хейнекен компанийн хэрэгжүүлдэг “Safety First”, “Амь насаа хамгаалах 12 амлалтыг” -ийг баримтлан ажилладаг.

- “Чи Чадна” төслийн гүйцэтгэл шил таталт **3,4 сая.ш** буюу **91%**, харилцагчийн хамралт болон хэрэглэгчид мэдээлэх тоон зорилт **100%** биелсэн нь энэхүү богино хугацааны үр дүнд чиглэсэн төслийг амжилттай болсон гэж дүгнэлээ.
- Эргэлтийн шилийг стандарт шаардлагын дагуу хүлээн авахад эцсийн хэрэглэгчийг шууд эргэлтийн шилний процесст оролцуулах буюу шилээ ялган ангилж шууд шилний цэгт тушаадаг болгон хэвшүүлэх, компани архины эргэлтийн сав баглаа боодол зориулалтын авдар савыг нэмэгдүүлэх ,хорогдол багатай буцаан тээвэрлэх, шилний төлбөр тооцоог түргэн

шуурхай хүртээмжтэй болгох, эргэлтийн шилийг хүлээн авах угаах үйл ажиллагааг сайжруулах хүчин чадлыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай.

- Бид 2022 ондоо Байгаль орчны аудит, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэсэн ба ажлын байр болон хүрээлэн буй орчныхоо сөрөг нөлөөлөл, аюул эрсдэлийг бууруулан амжилттай ажилласан.
